

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 2 дахь заалтад доор дурдсан агуулгатай дараахь заалт нэмсүгэй:

“-оюуны өмч, патент, зохиогчийн эрхийн асуудал;  
-өндөр технологи, үндэсний инновацийн тогтолцоог бүрдүүлэх, хөгжүүлэх асуудал;”

**2 дугаар зүйл.** Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар 5 дахь хэсгийн 7 дахь заалтын “-оюуны өмч, патент, зохиогчийн эрхийн асуудал;”, мөн хэсгийн 10 дахь заалтын “-өндөр технологи, үндэсний инновацийн тогтолцоог бүрдүүлэх, хөгжүүлэх асуудал;” гэснийг тус тус хассугай.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг 2018 оны ... дугаар сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны . . . дугаар  
сарын . . . -ны өдөр

Дугаар . . .

Улаанбаатар  
хот

### **Монгол Улсын Их Хурлын 2016 оны 12 дугаар тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай**

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын 2016 оны 12 дугаар тогтоолын хавсралтад Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээнд “1.<sup>1</sup> Оюуны өмч, инновацийн газар” гэсэн Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг нэмсүгэй.

2. Тогтоолын хавсралтын Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээн дэх “5. Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар” гэснийг “5. Улсын бүртгэлийн ерөнхий газар” гэж өөрчилсүгэй.

3. Энэ тогтоолыг Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө..

Гарын үсэг